



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/30

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан “Миний Өвөрхангай” танин мэдэхүйн ном бэлтгэн хэвлүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Ундрах -аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд: Б.Сайнжаргал –аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Ж.Пүрэвсүрэн –аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Т.Ариунболд –аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
С.Цэдэнбалжир - аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Ч.Батсуурь –аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Д.Тогтох -аймгийн Музейн дарга
Л.Пүрэвлхам - аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Соёл, урлагийн хэлтсийн дарга
С.Чинбат -аймгийн Гэрэл зураг, унадаг дугуйн холбооны тэргүүн (зөвшилцсөнөөр)
Нарийн бичгийн дарга: М.Долгорсүрэн - аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн

2.Номыг 2021 оны 06 дугаар сарын 01-ний дотор боловсруулах ажлыг удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсэг (С.Ундрах)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100072